

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС, БҮГД НАЙРАМ-  
ДАХ АРДЧИЛСАН СОЛОНГОС АРД УЛСЫН ХООРОНД  
ИРГЭН, ГЭР БҮЛ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР  
ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ  
Г Э Р Э Э

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан  
Солонгос Ард Улс,

Хоёр орны хоорондын найрамдалт харилцааг гүнзгийрүүлэн  
хөгжүүлэх, эрх зүйн харилцааны салбарт хамтын ажиллагаагаа  
бэхжүүлэх зорилгоор энэхүү Гэрээг байгуулахаар шийдвэрлэж  
дорхи зүйлийг хэлэлцэн тохиров.

I ХЭСЭГ

НИЙТЛЭГ ЗААЛТ

I дүгээр зүйл

Эрх зүйн хамгаалалт

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа хувийн болон эд хөрөнгийн эрхийн хувьд тэрхүү улсын иргэдийн нэгэн адил эрх зүйн хамгаалалтад байна.

2. Энэ заалт нь Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

2 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэх

Хэлэлцэн тохирогч Талууд эрх зүйн туслалцааг шүүх, прокурор, улсын нотариатын болон эрх бүхий бусад төв байгууллагаар дамжуулан үзүүлнэ.

3 дугаар зүйл

Эрх зүйн туслалцааны хэмжээ

Хэлэлцэн тохирогч хоёр Тал байцаан шийтгэх ажиллагааны тодорхой үйлдэл хийх, тухайлбал нэгжлэг хийх, эд зүйлсийг хураан

авах, битүүмжлэх, эд мөрийн баримт хургуулах болон шилжүүлэх, зохигчид, гэрч, шинжээч, сэжигтэн болон яллагдагч, шүүгдэгч, ялтныг байцаах, шүүхийн үзлэг хийх, баримт бичиг гардуулах, даалгаврыг биелүүлэх, материал, хэргийг хургуулах, баримт бичиг үйлдэх, орчуулах, хургуулах, хэрэгтнийг баривчлах, шилжүүлэхтэй холбогдсон асуудлаар эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

#### 4 дүгээр зүйл

##### Даалгаврын агуулга, хэлбэр

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт:

а/ даалгавар өгч байгаа байгууллагын нэр;

б/ даалгавар хүлээн авах байгууллагын нэр;

в/ эрх зүйн туслалцаа авахаар хүсэлт тавигдаж байгаа хэргийн нэр;

г/ зохигчид, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон ялтны овог нэр, тэдний байнга буюу түр оршин суугаа газар, иргэний харьяалал, эрхэлдэг ажил, боломжтой бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон ялтны төрсөн газар, он, сар, өдөр;

д/ зохигчдын төлөөлөгчдийн овог нэр, хаяг;

е/ даалгаврын агуулга, түүнийг биелүүлэхэд шаардагдах мэдээ, гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тусгасан байвал зохино.

2. Даалгаврын дагуу илгээх баримт бичиг нь гарын үсэг, тэмдэгтэй байна.

#### 5 дугаар зүйл

##### Даалгавар биелүүлэх журам

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ. Гэхдээ даалгавар хүлээн авсан байгууллага хэрэв өөрийн

улсын хууль тогтоомжид харшлахгүй бол даалгавар өгсөн байгуулагын хүсэлтээр тэрхүү улсын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.

2. Даалгавар хүлээн авсан байгууллага хэрэв уг даалгаврыг биелүүлэх эрхгүй байвал түүнийг эрх бүхий байгууллагад шилжүүлэн өгч, энэ тухайгаа нөгөө Талд харху мэдэгдэнэ.

3. Даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг биелүүлсний дараа холбогдох баримт бичгийг даалгавар өгсөн байгууллагад явуулна. Даалгавар хүлээн авсан байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлж чадаагүй бол холбогдох баримт бичгийг буцааж, даалгаврыг биелүүлэхэд саад болж байгаа шалтгааныг даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэнэ.

#### 6 дугаар зүйл

##### Баримт бичгийг гардуулах журам

1. Гардуулах баримт бичиг нь энэхүү Гэрээний 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байвал тухайн улсад баримт бичиг гардуулах журмыг зохицуулж байгаа хууль тогтоомжийн дагуу даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг гардуулна.

2. Даалгаварт заасан хаягаар баримт бичгийг гардуулах боломжгүй бол даалгавар хүлээн авсан байгууллага хаяг тогтоох арга хэмжээ авна. Даалгавар хүлээн авсан байгууллага хаяг тогтоох боломжгүй бол энэ тухай даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэж, гардуулбал зохих баримт бичгийг түүнд буцаана.

#### 7 дугаар зүйл

##### Баримт бичиг гардуулсныг нотлох

Баримт бичиг гардуулсан тухай нотолгоог даалгавар хүлээн авсан Халалцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа журмын дагуу үйлдэх бөгөөд түүнд гардуулсан он, сар, өдөр, газрыг заасан байна.

## 8 дугаар зүйл

## Баримт бичгийг нотлох чадвар

1.Халалцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хэлбэрийн дагуу үйлдсэн буюу гэрчилсэн баримт бичиг нь Халалцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ямар нэгэн өөр баталгаагүйгээр нотлох чадвартай байна.

2.Халалцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт үйлдсэн албан бичиг нь Халалцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт албан ёсны баримт бичгийн хувьд нотлох чадвартай байна.

## 9 дүгээр зүйл

## Гэрч, шинжээчийн халдашгүй байдал

1.Халалцэн тохирогч нэг Талын байгууллага дуудлагаар ирсэн нөгөө Талын иргэн-гэрч, шинжээчийг гаргасан мэдүүлэг, дүгнэлттэй нь холбогдуулан эрүүгийн хариуцлагад татаж мөрдөх буюу эсвэл баривчилж, хорьж болохгүй.

2.Гэрч, шинжээчийн эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдож гарсан бүх зардлыг дуудсан Тал хариуцна.

## 10 дугаар зүйл

## Эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардал

Даалгавар хүлээн авсан Халалцэн тохирогч Тал эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдож өөрийнхөө нутаг дэвсгэрт гарсан зардлыг хариуцна.

## II дүгээр зүйл

## Эрх зүйн асуудлаархи мэдээлэл

Халалцэн тохирогч хоёр Тал нөгөө Талынхаа хүсэлтээр өөрийн улсын хууль тогтоомжийн үндсэн зарчим болон шинээр гарч буй

хууль тогтоомж, түүнийг хэрэглэх асуудлаар харилцан мэдээлэл хийж, холбогдох материал солилцож байна.

12 дугаар зүйл

Харилцах хэл

Энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч хоёр Тал бие биедээ гардуулах баримт бичгийг өөрийн хэлээр үйлдэж, түүнд орос буюу нөгөө Талын хэлний орчуулгыг хавсаргасан байвал зохино.

II ХЭСЭГ

ТУСТАЙ БҮЛЭГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ИРГЭНИЙ БОЛОН ГЭР БҮЛИЙН ХЭРГИЙН  
ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

13 дугаар зүйл

Шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөх

Хэлэлцэн тохирогч хоёр Тал шүүхийн ажиллагаанд оролцож байгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг шүүхийн зардал төлөх үүргээс чөлөөлж байна.

14 дүгээр зүйл

Баримт бичиг олгох, хургуулэх

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын байгууллагын хүсэлтээр түүнд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн болон бусад баримт бичгийг хургуулна.

2. Холбогдох этгээдийн хувийн болон гэр бүлийн байдал, цалин, эд хөрөнгийн тухай тодорхойлолтыг хүсэлт гаргагчийн байнга буюу түр оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага олгоно.

15 дугаар зүйл

Эрх олох, үүрэг бий болгох чадвар

1. Иргэний эрх олох, үүрэг бий болгох чадварыг уг иргэнийг

харьяалах Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2.Хуулийн этгээдийн эрх олох, үүрэг бий болгох чадварыг уг хуулийн этгээдийн оршин байгаа улсын хууль тогтоомжоор тодорхойлно.

#### 16 дугаар зүйл

Сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, нас барсан үйл баримтыг тогтоох

1.Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоох хэргийг сүүлчийн мэдээ баримтаар уг иргэн амьд ахуй цагтаа харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллагууд өөрийн улсын хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэх эрхтэй байна.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын байгууллага нөгөө Талын иргэнийг нас барсан буюу сураггүй алга болсонд тооцох, эсвэл нас барсан үйл баримтыг тогтоож болно.

#### 17 дугаар зүйл

Гэрлэлт ба түүнийг цуцлах

1.Гэрлэх ба түүнийг цуцлах нөхцөл, түүнчлэн гэр бүлийн харилцаанаас үүссэн хувийн болон эд хөрөнгийн харилцааг гэрлэгсэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ.

2.Хэрэв гэрлэгсэд өөр өөр харьяалалтай байвал гэрлэлт буюу түүнийг цуцлах, хүчингүйд тооцохтой холбогдсон асуудлыг уг хэргийг хянаж байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ.

## 18 дугаар зүйл

Эцэг эх, хүүхдийн эрх зүйн  
харилцаа

Эцэг тогтоох болон энэ талаар гарсан маргаан, мөн эцэг эх, хүүхдийн хоорондын эрх зүйн харилцааг хүүхэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

## 19 дүгээр зүйл

Хүүхэд үрчлэх, түүнийг хүчин-  
гүй болгох

1. Хүүхэд үрчлэхэд үрчлэн авагч харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

2. Иргэний өөр өөр харьяалалтай эхнэр, нөхөр хүүхэд үрчлэн авч байгаа бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын нутаг дэвсгэрт мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хэрэглэж болно.

3. Үрчлэгдэж буй хүүхэд нь Хэлэлцэн тохирогч нэг Талын харьяат, үрчлэн авагч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын харьяат бол хүүхэд үрчлэх талаар хүүхэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид заасны дагуу тэр хүүхдийн өөрийн нь болон түүний хууль ёсны төлөөлөгч, Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авна.

4. Энэ зүйлийн 1, 2, 3-ын заалтыг хүүхэд үрчилснийг хүчингүй болгоход нэгэн адил хэрэглэнэ.

## 20 дугаар зүйл

Асран хамгаалах, харгалзан  
дэмжих

1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох тухай асуудлыг асран хамгаалуулах, харгалзан

дэмжүүлэх шаардлагатай хүн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2. Асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг хүлээн авахад асран хамгаалагч, харгалзан дэмжигч харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

21 дүгээр зүйл

Өв залгамжлал, гэрээслэл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийг хууль ёсоор буюу гэрээслэлээр өвлөн авах, мөн гэрээслэл үйлдэх, түүнийг хүчингүй болгохдоо Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнтэй адил тэгш эрх эдэлнэ.

2. Хөдлөх эд хөрөнгө өвлөх эрхийг өвлүүлэгч нас барах үедээ харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3. Үл хөдлөх эд хөрөнгө өвлөх эрхийг тухайн эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

4. Гэрээслэлийн хэлбэр, гэрээслэл үйлдэх болон хүчингүй болгох чадварыг тогтоох асуудлыг өвлүүлэгч гэрээслэл үйлдэх буюу хүчингүй болгох үедээ харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх,  
биелүүлэх

1. Хэлэлцэн тохирогч хоёр Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын



нутаг дэвсгэрт гарсан шүүхийн дараахь шийдвэрийг өөрийн нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрч биелүүлнэ:

а/ иргэний болон гэр бүлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр;

б/ эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдуулан гарсан таслан шийдвэрлэх тогтоол.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүх нөгөө Талын шүүхийн шийдвэрийг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг баримтална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН  
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

23 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх үүрэг

Хэлэлцэн тохирогч хоёр Тал өөрсдийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг энэхүү Гэрээнд заасан нөхцөлийн дагуу эрүүгийн хариуцлагад татах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор нөгөө Талын шаардсанаар харилцан шилжүүлэн өгөх үүрэг хүлээнэ.

24 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөхөөс татгалзах

Хэлэлцэн тохирогч хоёр Тал өөрийн харьяат иргэнийг шилжүүлэн өгөх тухай нөгөө Талын шаардлагаас татгалзана.

25 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай шаардлага

1.Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр шилжүүлэн өгөх тухай шаардлагад уг этгээдийн үйлдсэн гэмт хэргийн бүрэлдэхүүн, хэрэг-

лэх хуулийн зүйл анги, хэрэв гэмт хэргийн улмаас эд материалын хохирол учирсан бол түүний хэмжээ зэргийг заахын хамт баривчлах бол энэ тухай тогтоолын баталгаатай хуулбарыг хавсаргана.

2.Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэх зорилгоор шилжүүлэн өгөх тухай шаардлагад гэмт хэрэг гэж тодорхойлсон хуулийн зүйл ангийг зааж, таслан шийдвэрлэх тогтоолын баталгаатай хуулбарыг хавсаргана.Мөн шийтгэгдсэн этгээд ялынхаа зарим хэсгийг нэгэнт эдалсэн бол энэ тухай тодорхой тусгана.

3.Шилжүүлэн өгөх тухай шаардлагад тухайн этгээдийн хувийн байдал, биеийн болон нүүр царайны ерөнхий төрх, онцлог шинж, хурууны хээ, түүний фото зураг зэргийг бололцооны хэрээр тодорхойлж хавсаргана.

4.Хэрэв шилжүүлэн өгөх тухай шаардлагад зайлшгүй хэрэгцээтэй мэдээ агуулагдаагүй бол даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нэмэлт материал шаардаж, түүнийг ирүүлэх хугацааг тодорхойлж болно.

26 дугаар зүйл

Эрүүгийн хэрэг үүсгэх үүрэг

1.Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нөгөө Талынхаа нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн харьяат иргэндээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шаардлагаар өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэх үүрэг хүлээнэ.

2.Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал уг эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын дунг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэх бөгөөд хэрэв таслан шийдвэрлэх тогтоол гарч хуулийн хүчин төгөлдөр болсон бол түүний хуулбарыг хүргүүлнэ.

## II

### 27 дугаар зүйл

#### Баривчлах, шилжүүлэх

1. Энэхүү Гэрээнд заасан нөхцөлийн дагуу шилжүүлэн өгөх буюу баривчлах тухай шаардлага хүлээн авсан Халалцэн тохирогч Тал уг этгээдийг нэн даруй эрэн сурвалжилж олох, баривчлах арга хэмжээ авна.

2. Халалцэн тохирогч нэг Тал нутаг дэвсгэртээ байгаа Халалцэн тохирогч нөгөө Талын иргэн өөрийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийг мэдвэл тэрхүү Талын шаардлагыг хүлээхгүйгээр уг этгээдийг баривчилж болно.

3. Халалцэн тохирогч нэг Тал энэхүү зүйлийн I, 2-т заасан ёсоор баривчилсан тухайгаа Халалцэн тохирогч нөгөө Талд нэн даруй мэдэгдэнэ.

4. Баривчилсан тухай мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор Халалцэн тохирогч нөгөө Тал шилжүүлэн өгөх тухай шаардлага ирүүлэхгүй бол баривчилсан этгээдийг суллаж, энэ тухай нөгөө Талд мэдэгдэнэ.

### 28 дугаар зүйл

#### Шилжүүлэн өгөх журам

1. Даалгавар хүлээн авсан Халалцэн тохирогч нэг Тал уг этгээдийг шилжүүлэн өгөх газар, хугацааг даалгавар өгсөн Халалцэн тохирогч нөгөө Талд мэдэгдэнэ.

2. Шилжүүлэн өгвөл зохих этгээд нь даалгавар хүлээн авсан улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэгт татагдсан буюу ял эдэлж байгаа бол уг хэргийг мөрдөж дуусгах, эсвэл ялыг нь эдэлж гүйцэтгэл түүнийг шилжүүлэхийг хойшдуулж болно.

## 29 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөх тухай хэд хэдэн  
улсын шаардлага

Шилжүүлэн өгөх шаардлага хэд хэдэн улсаас ирвэл даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал юуны өмнө шилжүүлэн өгөх этгээдийн иргэний харьяалал, түүнчлэн гэмт хэргийн хүнд, хөнгөний байдал, гэмт хэрэг үйлдсэн газрыг харгалзан үзэж, Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шаардлагыг илүү анхаарч шийдвэртэнэ.

## 30 дугаар зүйл

## Эд зүйлийг шилжүүлэх

1. Хэлэлцэн тохирогч нэг Тал гэмт этгээдийг шилжүүлэхдээ түүний хэрэг үйлдэх үедээ ашиглаж байсан эд зүйл болон гэмт хэргийн замаар олсон мөнгө, эд зүйлийг нөгөө Талдаа өгнө.

Энэхүү мөнгө, эд зүйлийг гэмт этгээд нь нас барсан ч нөгөө Талдаа шилжүүлэн өгнө.

2. Энэ зүйлийн I-д заасан мөнгө, эд зүйлийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шүүн таслах ажиллагаа дууссаны дараа уг зүйлсийг эргүүлэн авах эрх бүхий этгээдэд шилжүүлэх зорилгоор даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч нөгөө Талд эргүүлэн өгнө.

3. Энэхүү зүйлийн I, 2-г дурдсан мөнгө, эд зүйл нь гаалийн татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

## 31 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөхтэй холбогдсон  
зардал

Шилжүүлэн өгөхөд бэлтгэх зардлыг шилжүүлэн өгч байгаа Тал, бусад бүх зардлыг шаардлага тавьсан нөгөө Тал хариуцна.

## 32 дугаар зүйл

Эрүүгийн мөрдөн байцаалтын  
дунг мэдэгдэх

1. Халалцэн тохирогч хоёр Тал шилжүүлэн авсан этгээдийн талаар явуулсан эрүүгийн мөрдөн байцаалтын дунг харилцан мэдээлж байна. Тухайн этгээдийн хувьд таслан шийдвэрлэх тогтоол гарсан бол түүнийг хүчин төгөлдөр болсны дараа хуулбарыг илгээнэ.

2. Халалцэн тохирогч хоёр Тал Халалцэн тохирогч нөгөө Талынхаа иргэнийг шийтгэсэн бол энэ тухайгаа харилцан мэдээлж байна.

## III ХЭСЭГ

## ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

## 33 дугаар зүйл

## Зөвлөлдөх, хамтран ажиллах

Халалцэн тохирогч Талууд энэхүү Гэрээг амжилттай хэрэгжүүлэх, гэмт этгээдүүдтэй тэмцэхэд хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийн тулд хуулийн холбогдох төв байгууллагуудын хооронд буюу дипломат шугамаар харилцан зөвлөлдөж, хамтран ажиллах явдлыг идэвхжүүлнэ.

## 34 дүгээр зүйл

## Соёрхон батлах, хүчин төгөлдөр болох

Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичгийг Пхеньян хотод солилцсоноос хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү Гэрээний хүчинтэй байх хугацаа таван жил бөгөөд Халалцэн тохирогч хоёр Талын аль нэг нь тухайн хугацаа дуусахаас зургаан сарын өмнө энэ Гэрээг цуцлах тухайгаа бичгээр эс мэдэгд-

вал түүний хүчинтэй байх хугацаа нь тав таван жилээр сунгагдаж байна.

Энэхүү Гэрээг 1988 оны аравдугаар сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо монгол, солонгос хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд хоёр эх нь адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ  
АРД УЛСААС ЭРХ  
ОЛГОСНООР



БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН  
СОЛОНГОС АРД УЛСААС ЭРХ  
ОЛГОСНООР



몽골인민공화국과 조선민주주의인민공화국  
사이에 민사, 가족 및 형사 사건들에서  
법률상방조를 서로 출태 대한 조약

몽골인민공화국과 조선민주주의인민공화국은 두 나라 사이의 친선  
관계를 심화발전시키며 법률관계분야에서 협조를 강화할 목적으로 이  
조약을 체결하기로 결정하고 다음과 같이 합의하였다.

## 제 1 편 총 칙

### 제 1 조

#### 법률상 보호

1. 계약일방의 공민은 계약상 상대방의 령역에서 주재국 공민과 같은  
인격상 및 재산상 권리에 대한 법률상보호를 받는다.
2. 이 조항은 계약상 상대방의 법인에게도 동일하게 적용된다.

### 제 2 조

#### 법률상방조의 제공

계약쌍방은 법률상방조를 재판소, 검찰소, 국가공증기관, 기타 권한

있는 중앙기관을 통하여 준다.

### 제 3 조

#### 법률상방조의 범위

체약쌍방은 구체적인 소송행위 즉 수색, 재산에 대한 압수와 차압, 증거물의 발송과 이관, 당사자, 증인, 감정인, 피의자, 피심자, 피소자, 범죄자에 대한 심문, 재판심리, 문건전달, 위임리행, 자료발송과 사건의 이관, 문건 작성, 번역 및 발송, 범죄자의 체포, 인도와 관련한 문제들에서 법률상방조를 제공한다.

### 제 4 조

#### 의뢰 내용과 형식

1. 법률상방조를 줄데 대한 의뢰에는 다음과 같은 내용들이 포함되어야 한다.
  - 1) 의뢰하는 기관명
  - 2) 의뢰받는 기관명
  - 3) 법률상방조가 요구되는 사건명
  - 4) 당사자, 피의자, 피심자, 피소자, 범죄자의 성명, 그들의 항시적 및 임시적 거주지, 국적, 직업 그리고 가능한한 피의자, 피심자, 피소자, 범죄자의 출생지와 생년월일



5) 대리인의 성명과 주소

6) 의뢰내용과 그것을 리행하는데 필요한 자료, 범죄구성에 대한 자료

2. 의뢰하는 문건에는 서명이 있어야 하며 공인이 찍혀있어야 한다.

## 제 5 조

### 의뢰 리행 절차

1. 법률상방조를 줄것을 의뢰받는 기관은 그것을 리행함에 있어서 자기 나라의 법규범을 적용한다.

그러나 의뢰받는 기관은 의뢰하는 기관의 요청에 따라 자기 나라의 법에 저촉되지 않는한 의뢰하는 나라의 소송법규범을 적용할수 있다.

2. 만약 의뢰받는 기관이 의뢰를 리행할 권한이 없는 경우 그것을 권한있는 기관에 이관하며 이에 대하여 상대측에 통지한다.

3. 의뢰받은 기관은 그것을 리행한 다음 해당한 문건을 의뢰한 기관에 보낸다.

의뢰받은 기관이 법률상방조를 줄수 없으면 해당 문건을 반환하며 의뢰를 리행함에 있어서 장애로 되었던 사실을 의뢰한 기관에 통보한다.

## 제 6 조

### 문 건 전 달 절 차

1. 의뢰받은 기관은 전달하는 문건이 이 조약 제12조의 요구대로 작성된 경우 자기 나라에서 적용되는 문건전달절차에 따라 그것을 전달한다.
2. 의뢰에 지적된 주소대로 문건을 전달할 수 없다면 의뢰받은 기관은 주소를 확정하기 위한 대책을 세운다. 의뢰받은 기관이 주소를 확정할 수 없는 경우 이에 대하여 의뢰한 기관에 통보하며 전달하게 되었던 문건을 돌려준다.

## 제 7 조

### 문 건 전 달 의 확 인

문건전달확인서는 의뢰받은 계약당사국령역에서 적용되고있는 규정에 따라 작성되며 여기에는 전달한 날자와 장소가 지적되어야 한다.

## 제 8 조

### 문 건 의 증빙력

1. 계약일방의 령역에서 권한을 가진 기관 또는 공식인물들이 제정

된 형식에 따라 작성되었거나 증명한 문건은 계약상대방의 령역에서도 공증함이 없이 증빙력을 가진다.

2. 계약일방의 령역에서 작성된 공식문건은 계약상대방의 령역에서도 공식문건으로서의 증빙력을 가진다.

## 제 9 조

### 증인과 감정인에 대한 불가침

1. 계약당사국기관에 출석한 상대방 공민인 증인 또는 감정인은 증언 및 평가와 관련하여 형사책임을 추궁당하거나 체포구금될수 없다.
2. 법률상방조와 관련한 증인, 감정인의 모든 비용은 소환측이 부담한다.

## 제 10 조

### 법률상 방조의 비용

의뢰받은 계약일방은 자기의 령역에서 법률상 방조를 주는데 드는 모든 비용을 부담한다.

제 11 조

법률문제에 관한 통보

체약쌍방은 상대방의 요청에 따라 자기 나라 법의 기본원칙과 새로 나온 법규범 그리고 그의 리행과 관련한 문제를 서로 통보하며 해당한 자료를 교환한다.

제 12 조

용어

이 조약의 리행과 관련하여 체약상대방에 전달하는 문건은 자기 나라 어문으로 작성되며 여기에 로어문 또는 상대방 어문으로 된 번역문이 첨부되어야 한다.

제 2 편 각 칙

제 1 장

민사 및 가족 사건에 대한 법률상방조

제 13 조

소송비용의 면제

채약상대방 재판소에 소송을 제기하는 채약일방의 공민은 소송료를 면제받는다.

제 14 조

문건의 발급과 발송

1. 채약일방은 요청에 따라 채약상대방 공민의 신분등록에 관한 문건과 기타 문건을 채약상대방에 보낸다.
2. 해당 인물의 일신상문제, 가정형편, 로임과 재산에 관한 문건은 신청자가 항시적으로 거주 또는 임시체류하고있는 채약일방의 권한있는 기관에서 발급한다.

제 15 조

권리능력과 행위능력

1. 공민의 권리능력과 행위능력은 그가 공민으로 되어있는 나라의 법에 의하여 규정된다.
2. 법인의 권리능력과 행위능력은 법인이 있는 나라의 법에 의하여

규정된다.

## 제 16 조

### 행방불명자, 사망자 인증과 사망사실의 확인

1. 행방불명자, 사망자 인증과 사망사실의 확인은 마지막 자료에 의하여 살아있을 당시 공민으로 되어있던 계약당사국기관이 자기나라의 법을 적용하며 결정할 권한을 가진다.
2. 계약일방의 법기관이 상대방 공민의 사망 또는 행방불명을 인증하며 사망사실을 확인한다.

## 제 17 조

### 결혼과 리혼

1. 결혼과 리혼, 그로 인한 부부의 인격적 및 재산적 관계는 부부가 공민으로 되어있는 계약국의 권한있는 기관이 자기 나라 법에 따라 결정한다.
2. 부부가 서로 다른 공민인 경우에는 결혼과 리혼문제, 결혼부효를 취급하는 계약국의 권한있는 기관이 자기 나라 법에 따라 결정한다.

## 제 18 조

### 부모와 자녀 사이의 법적관계

아버지를 확인하는 사건과 그에 대한 분쟁사건 그리고 자녀와 부모 사이의 법적관계는 자녀가 공민으로 되어있는 계약국의 권한 있는 기관이 자기 나라 법에 따라 결정한다.

## 제 19 조

### 립양과 파양

1. 립양은 양친이 공민으로 되어있는 계약국의 법을 적용한다.
2. 서로 다른 공민권을 가진 부부가 자녀를 립양할 때에는 계약 쌍방의 령역에서 실시되고있는 법을 적용할수 있다.
3. 립양되는 자녀가 계약일방의 공민이고 양친이 계약상대방의 공민인 경우 립양은 자녀가 공민으로 되어있는 계약국법이 요구하면 자녀와 그의 법정대리인 또는 계약국의 권한있는 기관의 동의를 받아야 한다.
4. 이 조 1, 2, 3항은 파양할 때에도 적용된다.

## 제 20 조

### 후견 및 보좌

1. 후견인과 보좌인을 확정할 때 관한 문제는 이 조약에 달리 예견되어 있지않는한 피후견인 또는 피보좌인이 공민으로 되어있는 계약국기관이 자기 나라 법에 따라 결정한다.
2. 후견 또는 보좌를 접수할 의무는 앞으로 후견인 또는 보좌인으로 될 사람이 공민으로 되어있는 계약국의 법에 따라 결정한다.

## 제 21 조

### 상속과 유언

1. 계약일방의 공민은 계약상대방의 영역에 있는 재산을 법정상속 또는 유언상속할 때 그리고 유언서를 작성 또는 취소할 때 계약상대방의 공민과 같은 권리를 행사한다.
2. 동산에 대한 상속사건은 사망당시 피상속인이 공민으로 되어있던 계약국의 법에 따라 결정한다.
3. 부동산에 대한 상속사건은 부동산소재지 계약국의 법에 따라 결정한다.
4. 유언의 형식, 유언서의 작성과 취소능력은 피상속인이 유언하거나 유언서를 작성 또는 취소할 때 공민으로 되어있던 계약국의 법



에 따라 결정한다.

## 제 22 조

### 판결의 인증 및 집행

1. 계약쌍방은 상대방의 령역에서 선고된 다음과 같은 판결을 자기의 령역에서 인증하며 집행한다.
  - 1) 민사 및 가족 사건에 대한 판결
  - 2) 형사사건에서의 손해보상에 관한 판결
2. 계약국재판소는 상대방의 판결을 집행할 때 자기 나라 법을 적용한다.

## 제 2 장

### 형사사건에 대한 법률상 방조

## 제 23 조

### 인도의 의무

계약쌍방은 이 조약에 규정된 조건에 따라 형사책임을 추궁하거나 판결을 집행하기 위하여 자기 나라 령역안에 있는 혐의자들을 상대방의 요구에 따라 호상 넘겨줄 의무를 지닌다.

제 24 조

인도의 기부

체약쌍방은 자기 나라 공민을 인도해줄데 대한 상대방의 요구를 거부한다.

제 25 조

인도의 요구

1. 형사책임을 추궁하기 위한 인도의 요구서에는 체포할데 대한 결정서의 인증된 사본, 범죄혐의자료, 적용할 법조항문이 첨부되어야 하며 물질적손실이 있었을 경우 그 정도를 지적해야 한다.
2. 판결집행을 위한 인도의 요구서에는 인증된 확정판결문사본과 범죄로 확정된 법조항문이 첨부되어야 한다.  
또한 형벌을 받은자가 이미 형벌의 일부를 집행하였다면 이에 대하여 명백히 밝혀야 한다.
3. 인도의 요구서에는 가능한한 인도될자의 인물식별조서를 붙여야 하며 그의 신분, 얼굴표상, 일반형태, 개별특징, 사진, 지문자료 등이 포함되어야 한다.
4. 만약 인도의 요구서에 필요한 내용을 갖추지 못하면 의뢰받은 체약일방은 보충자료를 요구하며 그에 대한 회보기간을 정할수 있다.

제 26 조

형사소추를 제기할 의무

1. 계약일방은 상대방의 요구에 따라 자기 국민이 상대방 나라에서 죄를 범하였을 때 자기 나라 법에 근거하여 형사소추를 제기할 의무를 지닌다.
2. 의뢰받은 계약국은 형사소추결과를 의뢰한 상대방에 통보하며 판결이 선고되고 그것이 확정되면 판결문사본을 보내준다.

제 27 조

체포와 인도

1. 계약일방은 인도 및 체포에 대한 요구를 제기받은 후 이 조약에 따라 인도할자를 즉시 찾아내고 체포하기 위한 대책을 세운다.
2. 계약일방은 자기 나라 영역에 있는 상대방국민이 자기 영역에서 범죄를 감행하였다는것을 알고있는 경우 요청없이도 그를 체포할 수 있다.
3. 계약일방은 이 조 1, 2항에 따라 체포한 정형을 계약상대방에 즉시 알려야 한다.
4. 체포한데 대하여 통보한 때로부터 30일이내에 계약상대방이 인도의 요구를 보내오지 않으면 체포한자를 석방하고 이를 상대방

에 통보한다.

## 제 28 조

### 인 도 절 차

1. 의뢰받은 체약일방은 인도를 요구한 체약상대방에 그 인물의 인도 장소와 시기를 알려준다.
2. 인도되어야 할자가 의뢰받은 체약일방의 령역에서 형사책임을 추궁당하고있거나 형벌을 받고있는 경우 형사소추 또는 형벌집행이 끝날때까지 인도를 연기할수 있다.

## 제 29 조

### 여러 나라로부터 제기된 인도

의뢰받은 체약일방은 여러 나라로부터 인도의 요구가 제기된 경우 무엇보다 먼저 인도될자의 국적 그리고 범죄의 경중, 범죄장소를 고려하여 체약상대방의 요구를 더 중시하며 실현한다.

## 제 30 조

### 물 품 인 도

1. 체약일방은 범죄자인도와 함께 범죄행위에 리용된 물품들과 범죄

행위로 취득한 돈과 물품들을 계약상대방에 인도해야 한다.

이 돈과 물품들은 범죄자가 죽은 경우에도 인도되어야 한다.

2. 이 조 1항의 돈과 물품을 넘겨받은 계약국은 사건심의를 끝나면 그것들을 넘겨받을 권리를 가지고있는 사람에게 넘겨주기 위하여 그것을 의뢰받은 상대방에 반환해야 한다.

3. 이 조 1, 2항에 따라 넘겨주는 돈과 물품은 관세와 세금을 물지않는다.

### 제 31 조

#### 인도의 비용

범죄자를 넘겨줄 때까지의 비용은 넘겨주는 측이 부담하며 그외의 비용은 요구한 측이 부담한다.

### 제 32 조

#### 형사소추결과에 대한 통보

1. 계약쌍방은 인도한자에 대하여 형사소추한 결과를 서로 통보한다. 만일 인도된자가 판결을 받았다면 판결이 확정된 다음 그 사본을 보내준다.
2. 계약쌍방은 계약상대방국민에게 판결을 내렸다면 그에 대하여 서로 통보한다.

제 3 편 최종규정

제 33 조

협 의 와 협 조

체약쌍방은 이 조약을 성과적으로 리행하며 범죄자들과의 투쟁에서 협조를 강화하기 위하여 해당 중앙법기관들사이에 또는 외교적 경로를 통하여 협의와 협조를 적극 강화하도록 한다.

제 34 조

비 준 및 효 력

이 조약은 비준되어야 하며 평양에서 비준서가 교환된 날 부터 30 일만에 효력을 가진다.

이 조약의 유효기간은 5 년간이며 체약쌍방중 어느 일방이 유효기간이 끝나기 6 개월전에 이 조약을 폐기할데 대한 의견을 서면으로 제기하지 않는한 그의 유효기간은 5 년간씩 연장된다.

이 조약은 1988년 10월 29일 울란바타르에서 서명되었으며 몽골어와 조선어로 각각 2부씩 작성된 이 두 원문은 같은 효력을 가진다.

몽골인민공화국의

조선민주주의인민공화국의

위 임 에 의 하 여

위 임 에 의 하 여



Gedogedo herreit oa Doibor

